




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ



Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 1.7%, 2023 онд: 4.9%
Инфляци: 2022 онд: 14.7%, 2023 онд: 11.6%

Урсгал тэнцэл: 2022 онд: -19.5%, 2023 онд: -16.8%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2022 оны тайланд прогнозыг хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: 2.5%

ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: -20.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORg>

Төсвийн тэнцэл 12-р сарын байдлаар 979.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 21 хувиар, зарлага 17 хувиар тус тус өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 979.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 66 хувиар буюу 1,929 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Лсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 8 хувиар өссөн бол, зарлага 16 хувиар өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1146.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.




Ам.долларын ханш өмнөх сараас 24.86 төгрөгөөр өсжээ.

12 сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 582.33 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 24.86 төгрөгөөр өсөж 3431.29 төгрөг болов. 12-р сард гадаад валютын нөөц 3.4 тэрбум ам.доллорт хүрч өнгөрсөн сараас 15.82 хувиар өсөж, оны эхнээс 22.14 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 22.14 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцын түвшин 13.2%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 12-р сарын байдлаар өмнөх сараас 1.0 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар, оны эхнээс 13.2 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 15.4 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 24.2 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 18.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 15.4 хувь, тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна



Гадаад худалдааны тэнцэл 3,836 сая.ам долларын ашигтай гарав.

2022 оны 12 сарын байдлаар нийт барааны эргэлт 21,245 сая ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 32 хувиар өссөн бол экспорт өмнөх оны мөн үеэс 36 хувь, импорт 27 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 3,836 сая ам.долларын ашигтай гарав.



12-Р САРЫН ОНЦЛОХ: ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦ

Эх сурвалж: www.mongolbank.mn

Монгол Улсын нийт гадаад валютын албан нөөц 2022 оны 12-р сард өмнөх сараас 15.8% өсөж 3.4 тэрбум ам.долларт хүрэв. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22% буурсан үзүүлэлт юм.

Гадаад валютын албан нөөцийн бүрэлдэхүүн хэсгийн задаргаа:

- Гадаад валютаар илэрхийлэгдэх нөөц - 2,890.40 сая ам.доллар
- Үнэт цаас: 1,807.02
- Нийт харилцах хадгаламж: 1,083.39 сая ам.доллар
-
- Олон улсын валютын санд байршуулсан хөрөнгө – 7.23 сая ам.доллар
- Зээлжих тусгай эрх – 121.08 сая ам.доллар
- Мөнгөжсөн алт /үүнд алтны хадгаламж, алтын своп хэлцэл зэрэг орно/ - 380.88 сая ам.доллар

САРЫН ОНЦЛОХ

МАЛЫН ТОО 71.1 САЯ БОЛЖ, ӨМНӨХ ОНООС 5.6 ХУВИАР ӨСЛӨӨ

- Улсын хэмжээгээр 2022 оны эцэст, мал тооллогын дүнгээр 71.1 сая толгой мал тоологдож, өмнөх оноос 3.8 сая (5.6%)-аар өслөө. Үүнээс адуу 4.8 сая, үхэр 5.5 сая, тэмээ 470.5 мянга, хонь 32.7 сая, ямаа 27.6 сая байна. Өмнөх онтой харьцуулахад хонь 1.7 сая (5.3%), үхэр 0.5 сая (9.8%), адуу 0.5 сая (11.5%), ямаа 1.1 сая (4.2%), тэмээ 16.4 мянга (3.6%)-аар тус тус өссөн байна. Оны эхний малын 1.0 хувь буюу 667.5 мянган том мал 2022 онд зүй бусаар хорогджээ.

ЭКСПОРТ ӨМНӨХ САРААС 22.9 ХУВИАР ӨСЛӨӨ

- Монгол Улс 2022 онд нийт 160 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 21.2 тэрбум америк доллар, үүнээс экспорт 12.5 тэрбум америк доллар, импорт 8.7 тэрбум америк доллар байна.
- БНХАУ-тай 2022 онд 13.7 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 64.3 хувийг эзэлж байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 12-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 12-р сар 2022 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn